



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө  
олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн их сургууль (бүрэлдэхүүн сургууль, салбар, нэгж)-ийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2022 онд нийт 670,000,000.00 (зургаан зуун далан сая) төгрөгт багтаан үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилт, худалдан авах үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал Т.Хэрүүгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр сард багтаан ирүүлэх.

3. Худалдан авсан хөрөнгийг бүртгэлд тусгах, энэ тогтоолын биелэлтийг тайлагнах ажилд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн  
дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ (БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ, НЭГЖ)-ИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ  
ҮҮСВЭРЭЭР ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	2022 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
<b>1.Барилга байгууламж, их засвар, өргөтгөл (өмнөх оноос)</b>					
1	ХААИС-Эдийн засаг, бизнесийн сургуулийн Номын сангийн барилга	ш	2017	1,500,000,000.00	50,000,000.00
2	ХААИС-Агроэкологийн сургуулийн Нарт, сургалт судалгааны төвийн цахилгааны иж шинэчлэл	ш	2022	120,000,000.00	120,000,000.00
<b>ДҮН</b>				<b>1,620,000,000.00</b>	<b>170,000,000.00</b>
<b>2. Өргөтгөл, Их засвар</b>					
1	ХААИС-ийн хичээлийн төв байранд дээврийн их засвар	ш	2022	70,000,000.00	70,000,000.00
<b>Барилга, байгууламж, өргөтгөл, их засварын нийт дүн</b>				<b>70,000,000.0</b>	<b>70,000,000.00</b>
<b>3. Тоног төхөөрөмж</b>					
<b>3.1. ЗАХИРГАА</b>					
1	Багшийн хөгжил, сургалтын орчин, нөхцлийг сайжруулах зорилгоор компьютер, габлит, зөөврийн компьютер, бусад сургалтын тоног төхөөрөмж худалдан авах /хичээлийн 2-р байр баригдаж дуусахад худалдаж авах/	ш	1	200,000,000.00	200,000,000.00
<b>3.2.ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ</b>					
1	Инженер, технологийн сургуулийн ХАА-н тэнхимд "Ухаалаг газар тариалангийн лаборатори" байгуулах тоног төхөөрөмж	ш	1	20,000,000.00	20,000,000.00
2	Инженер, технологийн сургуулийн Машин судлалын тэнхимд "Барилгын материалын туршилтын лаборатори" байгуулах, түүний тоног төхөөрөмж	ш	1	20,000,000.00	20,000,000.00
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>3</b>	<b>240,000,000.00</b>
<b>4. Тавилга,эд хогшил, бусад үндсэн (биет бус) хөрөнгө</b>					
<b>4.1.ЗАХИРГАА</b>					
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй хичээлийн 2-р байранд оюутны ширээ, сандал, бусад эд хогшил худалдан авах	ш	1	100,000,000.00	100,000,000.00
2	Инженер, технологийн сургуулийн Цахилгаан хангамж, электроникийн тэнхимд "Цахилгаан түгээх сүлжээний виртуал лабораторь" -д программ хангамж нэвтрүүлэх	ш	1	40,000,000.00	40,000,000.00
3	Хичээлийн төв байрны оюутны зоогийн газарт тоног төхөөрөмж	ш	1	15,000,000.00	15,000,000.00
4	ХААИС-ийн хэвлэх цехэд олшруулах, хувилах машин худалдан авах	ш	1	15,000,000.00	15,000,000.00
<b>4.2.МАЛ АЖ АХУЙ, БИОТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ</b>					
5	Сургалтын баазад зориулсан бага оврын ачааны машин /Бонго/	ш	1	20,000,000.00	20,000,000.00
<b>Тавилга,эд хогшил, бусад үндсэн (биет бус) хөрөнгө</b>				<b>190,000,000.00</b>	<b>190,000,000.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>670,000,000.00</b>